



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 07 одөр

Дугаар 9/555

Мандалговь

Г Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 7  
улсын тооллого зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Соёлын ёвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийж журам"-ын 2.2, 2.4, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/648 дугаар тушаал, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн нийт нутаг дэвсгэрт харьяалах төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг 2018 оны 12 дугаар сарын 1-нээс 2019 оны 3 дугаар сарын 31-ний хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

Хоёр. Тооллогын ажлыг зохион байгуулахад шаардлагдах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Улсын тооллогоор сумдад ажиллах тулш шатахууны зардалд 433026 (Дөрвөн зуун гучин гурван мянга хорин зургаа) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488010700

Аймгийн Засаг даргын 2018 оны  
12 дугаар сарын 07. өдрийн  
A/65 тоот захирамжийн хавсралт

**СҮМДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ТАНХИМД УЛСЫН  
ТООЛЛОГО ХИЙХ АЖЛЫН ТӨСВИЙН ТООЦОО**

№	Сүмдүн нэрс	Явах зам /км/	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бурийн үнэ	Нийт үнэ
Шатахууны зардал						
1	Адаацаг	90	литр	16.2	1980	32076
2	Баянжагалан	60	литр	10.8	1980	21384
3	Гурван сайхан	105	литр	18.9	1980	37422
4	Говь-Угтаал	70	литр	12.6	1980	24948
5	Дэрэн	50	литр	9	1980	17820
6	Дэлгэрцогт	70	литр	12.6	1980	24948
7	Дэлгэрхангай	70	литр	12.6	1980	24948
8	Луус	55	литр	9.9	1980	19602
9	Сайхан - Овоо	80	литр	14.4	1980	28512
10	Өлзийт	150	литр	27	1980	53460
11	Өндөршил	100	литр	18	1980	35640
12	Хулд	45	литр	8.1	1980	16038
13	Цагаандэлгэр	80	литр	14.4	1980	28512
14	Эрдэнэдалай	90	литр	16.2	1980	32076
15	Сайнцагаан	100	литр	18	1980	35640
	ДҮН	1215	литр	218.7	1980	433026